



ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 20

Тавантолгой

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ
ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 60.1, 76.1.3 заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 14 цагаас Өмнөговь аймаг, “Тавантолгой” ХК-ийн хурлын танхимд хуралдуулахаар товлосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.
-Компаний 2014 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан
-Компаний үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
-2013оны ногдол ашиг хуваарилалтын тайлан, 2014 оны ногдол ашиг хуваарилах тухай
-Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны төсвийг батлах тухай
-Бусад
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 3 сарын 09-ний өдөрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2015 оны 02 сарын 27-ны өдөрөөр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийг Компаний тухай хуулийн 65.6-р хэсэгт заасан баримт бичигтэй танилцах бололцоо олгох зохион байгуулалтын арга хэмжээг авахыг гүйцэтгэх захирал Р.Сэддоржид үүрэг болгосугай.
6. Саналын хуудасны агуулгыг 1,2 дугаар хавсралтад зааснаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Б.Түвшинбаярыг, тооллогын комиссын даргаар Б.Цэрэнпагма, гишүүдээр Л.Нямжав, Т.Жамбал нарыг томилон ажиллуулсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах комиссын даргаар Д.Ганболд, гишүүдээр Ц.Мөнхдэлгэр, А.Идэрцог нарыг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулахыг комиссын дарга Д.Ганболд үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ТҮВШИНБАЯР